МЭДЭЭ · 2023 оны 8-р сарын 9

ЗӨРЧЛИЙН ХЭРГИЙН ГАРАЛТ ДОЛООДУГААР САРД БУУРЧЭЭ

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ГАЗАР

ЗӨРЧЛИЙН ТООН МЭДЭЭ
/2023.07.01-2023.08.01/

Нийт зөрчил 201.235 24.7%

Нийслэлд 127.772

Орон нутагт 73.463


Цагдаа	191.684
Гаалийн байгууллага	188
Татварын байгууллага	107
Гадаадын иргэн, харьяатын газар	285
Онцгой байдлын газар	24
Бусад	8722

Зөрчлийн улмаас учирсан хохирол 2.952.454.000 төгрөг

Төлөгдсөн хохирол 784.636.000 төгрөг

Шийтгүүлсэн хүн 191.638

Хуулийн этгээд 494





16-18 нас 0.08	36-45 нас 30.5%
18-25 нас 12.8%	46-55 нас 15.4%
26-35 нас 34.3%	56-аас дээш нас 7.07%

Буурсан зөрчил

Гаалийн тухай хууль зөрчих	15.487
Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих	342
Хүүхдийн эрхийг зөрчих	187
Татварын хууль зөрчих	73
Нийгмийн даатгалын тухай хууль зөрчих	24

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих 166.689



prokuror.mn

Улсын хэмжээнд 2023 оны 7 дугаар сарын байдлаар 201.235 зөрчлийн хэрэг бүртгэгдсэн нь 6 дугаар сартай харьцуулахад 24.7 хувиар буурсан байна.

Нийт зөрчлийн хэргийн 63.5 хувь нь Нийслэлд, 36.5 хувь нь орон нутагт бүртгэгдсэн бол 95.2 хувийг Цагдаагийн байгууллага, 4.8 хувийг бусад байгууллагын эрх бүхий албан тушаалтнууд шалгаж, шийдвэрлэжээ.

Дээрх хугацаанд 191.638 хүн, 494 хуулийн этгээд Зөрчлийн тухай хуульд зааснаар шийтгүүлсэн ба өмнөх сараас шийтгэл оногдуулсан хүн 22.5 хувиар, хуулийн этгээд 27.1 хувиар буурсан байна.

Зөрчил үйлдсэн хүмүүсийн 79.8 хувь нь эрэгтэй, 20.2 хувь нь эмэгтэйчүүд байгаа бол дийлэнх буюу 64.8 хувь нь 26-45 насныхан байна.

Өнгөрсөн долоодугаар сард үйлдэгдсэн зөрчлийг зургаадугаар сартай харьцуулахад Нийгмийн даатгалын тухай хууль зөрчих зөрчил 63.1 хувиар, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих 53.8 хувиар, Хүүхдийн эрхийг зөрчих зөрчил 43.2 хувиар, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих зөрчил 23.4 хувиар, Татварын хууль зөрчих зөрчил 12 хувиар, Гаалийн тухай хууль зөрчих зөрчил 8 хувиар тус тус буурчээ.

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/1591